

Хүнс, хөдөө аж ахуйн газар
2015 оны 08 дугаар сард зохион байгуулсан ажлын тайлан

Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар

Улсын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг Газрын даргын тушаалаар байгуулж бэлтгэл хангаж ажлыг зохион байгууллаа. Ажлын хэсэг удирдамжийн дагуу бэлтгэл хангах төлөвлөгөө боловсруулж ажиллав.

Газрын 2015 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд дотоод аудитыг хийж гарсан алдаа дутагдлыг засаж сайжруулах чиглэлээр зөвлөмж, дүгнэлт өгөв.

Мөн төрийн байгууллагуудаас хууль, эрх зүйн чиглэлээр сургалт авах төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулав.

Эд хөрөнгийн хагас жилийн тооллогыг зохион байгуулж эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт хийлээ. Ямар нэг зөрчил илрээгүй байна.

Хоёр:Салбарын хүрээнд

Мал аж ахуй салбар:

Монгол Улсын Засгийн газрын 292 дугаар тогтоол, 2015-2016 оны хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангуулах” тухай Улсын онцгой комиссын 2015 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн №3 тоот хурлын шийдвэр, өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Засгийн газрын 292 дугаар тогтоолын дагуу аймгийн аюулгүйн нөөцөд 32 тн өвс, 10 тн тэжээл, сумын аюулгүйн нөөцөд 50 тн өвс, 30 тн тэжээл бэлтгэхээс аймгийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэхэд Засаг даргын нөөц сангаас 18,5 сая төгрөгийг шийдвэрлүүлэн 1 боодол өвсийг 4500 төгрөгөөр буюу 5000 боодол өвс бэлтгэхээр Сэлэнгэ аймгийн Хушаат сумын иргэн Д.Баттулгатай гэрээ байгуулан 2015 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 01-ныг хүртлэх 1,5 сарын хугацаанд бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулсан байна.

Хадланд ажиллах техникийн бэлэн байдлын мэдээг d_bathuyag@yahoo.com хаягаар хүргүүлсэн байна. Мөн 2015 оны 08 дүгээр сарын 20-ны байдлаар өвс 873,4 тн, сүрэл 0,5 тн, үйлдвэрийн тэжээл 115,8 тн, гар тэжээл 5.0 тн, давс хужир, шүү 1,0 тн-ыг тус тус бэлтгээд байна.

“ПИН” ОУБайгууллагын “Хонины ноосоор барилгын дулаалгын материал хийж ашиглах хангамжийн сүлжээг бэхжүүлэх төсөл болон аймгийн ХАА-н Хоршоологчдын холбоотой хамтран “Малчид, ноосон дулаалгын материал үйлдвэрлэгчдийн ” уулзалтыг зохион байгуулж 4 сумын 30 гаруй хоршоодын гишүүн малчдыг хамруулж, “ЭКО НООС”-ын үйл ажиллагаатай танилцууллаа.

Мал эмнэлгийн салбар

Өвөлжилтийн бэлтгэл хангах талаар орон нутгийн нэгжүүдэд малын эмийн нөөц буй болгох, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх арга хэмжээг товллын хугацаандаа бүрэн хэрэгжүүлэх талаар үүрэг, чиглэл өгч ажиллаж байна.

Бог малын боом, сахуу, томуу зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх вакциныг татан авч, орон нутгийн МЭҮН-үүдэд хуваарийн дагуу олгож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ явагдаж байна.

Бог малын хамуу, бөөс ширхээс хамгаалах угаалга, туулгалтанд 98,5 мянган толгой мал хамрагдаад байна.

Орон нутгийн МЭҮН-үүд хаврын урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлсэний санхүүжилтээ авч чадаагүй байна.

Олон улсын худалдааны төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, мах сүүний лангуунаас долоо хоногт дээж авч зохих стандарт зааврын дагуу шинжилгээг хийж хариуг өгч ажиллаж байна.

Газар тариалангийн салбар

Ургацын урьдчилсан баланс гаргах ажлыг сумдын МЭҮТасагтай хамтран зохион байгууллаа. Энэхүү балансаар 14.4 мянган га-д буудай тариалж үүнээс 1210 га малын тэжээлд шилжиж, 2631.5 га ургац алдаж нийт 10349,1 га-аас 7552,9 тонн буюу 7,3 цн/га ургац хураан авах төлөвтэй байна. Төмс 440,5 га талбайд тариалсанаас 141,94 га талбай ургац алдаж 298,62 га талбайгаас 2100,63 тонн, хүнсний ногоо 954,48 га тариалснаас 328,21 га ургац алдаж 626,27 га-аас 5618,09 тонн, тосны ургамал 4809 га-д тариалсанаас 1446 га ургац алдаж 3363 га-аас 672,6 тонн ургац хураан авах урьдчилсан тооцоог гарсан байна.

Намрын ургац хураалтад 38 комбайн, төмс хүнсний ногооны 26 хураагч техник ажиллахаар засварын ажил хийгдэж байна. Өнөөдрийн байдлаар 33.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төмс, лууван, өргөст хэмх лоолийн түүвэрлэн хураах ажил эхэлсэн байна. Өнөөдрийн байдлаар 3,2 га-аас 20,8 тонн, хүнсний ногоо 12 га-аас 78 тонн ургац авсан мэдээтэй байна.

Тайланг нэгтгэсэн: Архив, Бичиг хэргийн эрхлэгч Д.Ганбаяр

Тайланг хянасан: ЗУХэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ

БАТЛАВ: ХХААГ-ЫН ДАРГА

Ц.ЭНХЖАРГАЛ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2015 ОНЫ 09 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийгдэх ажил	Огноо	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
Захиргаа удирдлагын хэлтэс				
1	Шарилжгүй дархан аяны хүрээнд байгууллагын ойр орчны цэвэрлэгээг зохион байгуулах.	9 сард	Б.Бат-Эрдэнэ	Гадна тохижилт, өнгө үзэмж сайжирна.
2	Төрийн байгууллагуудаас төлөвлөгөөт сургалтуудыг авах.	9 сард	Б.Бат-Эрдэнэ	Албан хаагчдын эрх зүйн мэдлэг нэмэгдэнэ.
3	Архивын улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг томилж ажиллуулах.	8 сард	Ажлын хэсэг	Архив, бичиг хэргийн стандарт, норм, дүрмийн мөрдөлт сайжирна.
Мал аж ахуйн хэлтэс				
4	Сумдын ноосны урамшууллын тайланг МХС-д хүргэх	Сардаа	МААХ	Сумдаас холбогдох журмын дагуу материалыг бүрдүүлэн авч хугацаанд нь холбогдох газарт хүргэсэн байна.
5	Улсын "Шилмэл мал-2015" арга хэмжээнд оролцох			Сумдаас иргэд, ААН-үүдийг хамруулж амжилттай

				оролцсон байна.
6	Малын ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн мэдээг нэгтгэх			Мэдээ, мэдээлэл үнэн зөв бодитой гарсан байна.
7	Хадлан, тэжээл бэлтгэлийн мэдээг эцэслэх			Сумдаас мэдээллийг үнэн зөв авч холбогдох байгууллагууд, удирдлагуудыг мэдээлэлээр хангасан байна.
Мал эмнэлгийн хэлтэс				
7	Бог малын боом, сахуу, томуу зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд өссөн дүнгээр 80,2 мянган толгой малыг хамруулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.	Сардаа	МЭХ, орон нутгийн МЭҮН	Хамрагдвал зохих бүх малын 90-ээс доошгүй хувийг бүрэн хамруулсан байна.
8	Бог малын хамуу, бөөс ширхээс хамгаалах угаалга, туулгалтанд өссөн дүнгээр 142,5 мянган толгой малыг хамруулах ажлыг зохион байгуулах	Сардаа	МЭХэлтэс, орон нутгийн МЭҮН	Хамрагдвал зохих бүх малын 90-ээс доошгүй хувийг бүрэн хамруулсан байна.
9	Орон нутгийн нэгжүүдийн тарилга хийсэн санхүүжилтийг олгуулах	Сардаа	МЭХэлтэс, МЭҮН-үүд	Санхүүжилтийг олгосон байна
10	Сарын ажлын мэдээ, тайланг хугацаандаа гаргах	Сардаа	МЭХэлтэс	Тайлан, мэдээг бүрэн гаргасан байна.
Хүнс, газар тариалангийн хэлтэс				
11	Ургацын урьдчилсан балансыг эцэслэн гаргаж хүргүүлэх	Сардаа	ХГТХэлтэс МЭҮТ	Тайлан, мэдээг бүрэн гаргасан байна.

12	Уринш боловсруулалт, ургац хураалтын техник засварын мэдээг эцэслэн гаргаж хүргүүлэх	Сардаа	ХГТХэлтэс МЭҮТ	Тайлан, мэдээг бүрэн гаргасан байна.
13	Буудай, төмсний үрийн үйлдвэрлэлд хянан баталгааг УГТЭШХ, МХГ-тай хамтран зохион байгуулах	Сардаа	ХГТХэлтэс МЭҮТ	Тайлан, мэдээг бүрэн гаргасан байна.
14	Улсын "Намрын ногоон өдрүүд-2015" арга хэмжээнд оролцох	Сардаа	ХГТХэлтэс МЭҮТ	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг бүрэн хамруулж оролцсон байна